

## МОНГОЛ УЛСАД БАЙРЛАЖ БАЙСАН ЗӨВЛӨЛТИЙН ЦЭРГИЙН АНГИУДЫГ ГАРГАХТАЙ ХОЛБОГДОХ ЗАРИМ БАРИМТ

Х.ОРХОНЧИМЭГ

*Доктор (Ph.D), дэд профессор  
БХЭШХ-ийн Аюулгүй байдал, батлан хамгаалах  
төвийн эрдэм шинжилгээний ажилтан*

**Хураангуй:** XX зуунд Монгол, Орос хоёр улс, төр, эдийн засаг, нийгэм, соёл, боловсрол, цэрэг батлан хамгаалах зэрэг бүхий л салбарт өргөн хүрээнд хамтран ажилласан онцлог түүхтэй билээ. Судлаачид хоёр орны хамтын ажиллагааны тухай тал бүрээс нь судлан баримт материал нийтлүүлсээр байгаа бөгөөд энэхүү өгүүлэлд Монгол Улсад байрлаж байсан Зөвлөлтийн цэргийн ангиудыг гаргахтай холбогдсон зарим баримтын тухай өгүүлэхээр зорилоо. Зөвлөлтийн цэргийн ангиудыг гаргах улс төрийн нөхцөл байдал, яриа хэлэлцээр хэрхэн явагдсан тухайд холбогдох архивын баримтуудыг тодруулж гаргах нь судалгаанд чухал ач холбогдолтой юм.

**Түлхүүр үг:** XX зуун, зөвлөлтийн цэрэг, яриа хэлэлцээр, баримт

Монгол, Оросын харилцаанд холбогдох баримт материалуудыг тодруулан судалгааны эргэлтэд оруулах нь цаашдын судалгаанд чухал ач холбогдолтой юм. Тэр дундаа хоёр улсын цэрэг батлан хамгаалах салбарт явагдсан онцлог үйл явдлууд, тэдгээрт холбогдох баримт материалуудыг судалгааны эргэлтэд оруулах шаардлага их байгаа юм. Энэхүү өгүүлэлд Монголд байрлаж байсан Зөвлөлтийн цэргийн ангиудыг гаргах улс төрийн шийдвэр гаргахтай холбогдсон зарим баримтуудыг тодруулахыг зорилоо.

XX зуунд Зөвлөлтийн арми хэд хэдэн удаа байрлаж, улс төрийн олон асуудлыг шийдэхэд зохих нөлөө үзүүлсэн. Гэвч Зөвлөлтийн цэргийг тухайн үед оруулах болсон шалтгаан, олон улсын байдал, гаргах болсон шалтгаан нөхцөл нь цэрэг стратегийн зорилттой холбоотой боловч энэ тухайд холбогдох баримт материалууд тодорхой судлагдаагүй байсаар байна. Иймээс хамгийн сүүлд Зөвлөлтийн цэргийн арми гаргахтай холбогдсон яриа хэлэлцээрт холбогдох зарим баримтын тухай өгүүлэх болно.

“БНМАУ, ЗСБНХУ-ын хооронд 1966 оны 1 дүгээр сард байгуулсан найрамдал, нөхөрлөл, харилцан туслалцах тухай гэрээний дагуу хоёр орны Засгийн газрууд БНМАУ-ын нутаг дэвсгэрт Зөвлөлтийн цэргийг байрлуулах тухай хэлэлцээрт 1967 оны 3 дугаар сарын 4-нд гарын үсэг зуржээ. Энэ үндсэн дээр Зөвлөлтийн цэргийн

анги 1967-1992 онд Монголд байрлаж байв. Хэлэлцээрийн 6 дугаар зүйлийн дагуу БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 59 удаагийн тогтоолоор (1969.08.11-1985.11.27) Зөвлөлтийн цэргийн ангиудад 410073,43 га газар олгосон байна. Энэ нь Улаанбаатар хотын 4 дүүрэг, 15 аймаг,” 64 сумын нутгийг хамарч байсан бөгөөд гол нь Булган, Орхон, Дорнод, Дорноговь, Дундговь, Төв, Говьсүмбэр аймгийн нутагт Зөвлөлтийн цэргийн дийлэнх байрлаж байв. Зөвлөлтийн цэргийн ангиудыг ямар үе шаттай, бүтэц бүрэлдэхүүнтэй оруулж байрлуулсан тухай бидэнд одоогоор баримт байхгүй байна. Харин Зөвлөлтийн цэргийг гаргах үеийн зарим мэдээ баримт байна. 1970-аад оны сүүлээс эхлэн Хятадын эрх баригчид БНМАУ-ын нутаг дэвсгэрээс Зөвлөлтийн цэргийн ангиудыг гаргах шаардлагыг Зөвлөлт Холбоот Улсын талд тавих болсон юм. Үүнтэй холбогдуулан БНМАУ-ын Засгийн газар 1978 оны 4 дүгээр сард Зөвлөлтийн цэргийн ангиудыг Монголд байрлаж байгаа учир шалтгаан нь Хятадын эрх баригчдаас Бүгд Найрамдах Монгол Ард Улсын талаар явуулж байгаа бодлогод л оршиж байгаа юм. Өөр шалтгаан байхгүй гэж мэдэгджээ.

1983 оны 10 дугаар сарын 27-ны өдөр БНМАУ-ын Гадаад Явдлын Яамны нэгдүгээр хэлтэст Ю.Цэдэнбал, М.С.Капицыг хүлээн авч уулзсан тухай тэмдэглэлд Оросын талаас “ ... манайх Хятадад айлчилж БНХАУ-ын ГЯЯ-ны орлогч сайд Цянь Цичэньтэй санал солилцсон. Хятадууд Зөвлөлт Хятадын харилцааг сайжруулахын тулд гурван болзол тавьсаны нэг нь Монголд байрлаж байгаа зөвлөлтийн цэргийн ангиудыг гаргах явдал юм. ... Монголд Зөвлөлтийн цэргийн анги байгаа асуудлаар Монголын тал Засгийн газрын мэдэгдэл гаргавал сайн байна. БНМАУ-ын байр суурь ямар байгааг тэдэнд ойлгуулахад энэ нь чухал юм гэхэд Монголын талаас талархал илэрхийлье. Бид Монголд байгаа Зөвлөлтийн цэрэг нь зөвхөн Хятадын аюулаас хамгаалах зориулалттай гэж ярьж бичдэг. Энэ нь учир дутагдалтай юм. Монголд байгаа Зөвлөлтийн цэргийн ангиуд нь бас бусад аюулаас хамгаалах зориулалттай. Азид империализмын аюул занал ихэсч байгаа үед уг цэрэг байгаа нь чухал ач холбогдолтой юм.” гэж ярилцсан байна.

“1980-аад оны эхнээс Зөвлөлт-Хятадын тусгай төлөөлөгчид Гадаад Явдлын Яамдын орлогч сайд нарын хэмжээнд улс төрийн зөвлөлдөх уулзалт хийх болсон. Энэ уулзалтын явцад ЗСБНХУ, БНХАУ-ын харилцааг хэвийн болгохтой холбогдуулан Хятадын талаас гаргаж тавьсан урьдчилсан нөхцөлүүдийн дотор “ БНМАУ-ын нутагт түр байрлаж байгаа Зөвлөлтийн цэргийн ангиудыг гаргах” гэсэн шаардлага байсаар ирэв. Энэ асуудалтай холбогдуулан БНМАУ-ын Засгийн газар 1984 оны 3 дугаар сарын 2-нд дахин мэдэгдэл гаргаж байв.”

Зөвлөлт Хятадын улс төрийн хэлэлцээ үр дүнд хүрч хоёр орны харилцаа хэвийн болох нөхцөл 1980-аад оноос бүрдэж эхлэв. Эл нөхцөлд Зөвлөлтийн тэргүүн М.С.Горбачев 1986 оны 1 дүгээр сарын 28-нд Владивостокт хэлсэн үгэндээ анх “Монгол Улсаас Зөвлөлтийн цэргийн үлэмж хэсгийг гаргах тухай асуудлыг БНМАУ-ын удирдлагатай одоо тохиролцож байна. гэж мэдэгджээ. Энэ тухай Элчин сайд Ц.Гүрбадамаас ГЯЯ-ны Нэгдүгээр орлогч сайд Д.Ёндонд дараах саналыг явуулж байжээ. Үүнд “ ... Манай ГЯЯ-ны сайд ЗХУ-д айлчлахтай

холбогдуулан доорх саналтай байна. Үүнд: ... Монгол Зөвлөлтийн хамтын ажиллагааны ач холбогдол, Монгол Хятадын харилцааны байдал, Монголоос Зөвлөлтийн цэргийн зарим хэсгийг гаргаж байгаа зэргийг тайлбарлаж ярих” зэрэг болно гэжээ.

БНМАУ, ЗСБНХУ-ын Засгийн газрууд ийнхүү тохиролцоонд хүрч Монгол Улсын нутаг дэвсгэрээс Зөвлөлтийн цэргийг хэд хэдэн үе шаттай гаргахаар шийдвэрлэжээ. “Эхний хэсгийг 1987 оны 4 дүгээр сард Монголын нутгаас гаргасан юм. Энэ бол ЗСБНХУ-ын Батлан хамгаалах яамны мэдээлснээр мотобуудлагын нэг дивизийг (Сайншандад байрлаж байсан) бүрэн бүрэлдэхүүнээр нь, мөн хэд хэдэн тусгай анги” байсан болно.

Энэ тухай 1987 онд БНМАУ-ын ГЯЯ-ны сайд ЗХУ-д албан ёсоор айлчилж, хоёр орны ГЯЯ-ны сайд нарын хооронд болсон хэлэлцээнд холбогдох баримтад Монголын талаас “... дөрөвдүгээр сард Монголоос Зөвлөлтийн цэргийн зарим анги салбарыг гаргаж эхлэхтэй холбогдуулан гадны юуны өмнө хөрөнгөтөн орны сурвалжлагчид манайд очих хүсэлт тавьж байна гэхэд Оросын талаас энэ асуудлыг Улаанбаатарт яриад шийдчихсэн. Гурван газарт албан ёсны үдэлтийн арга хэмжээ болохын нэгд нь гадныхныг оруулж болох юм гэж ярьсан. Гэхдээ нутгийн гүнд биш, хил орчимд байх нь зүйтэй байна.” гэжээ.

Үүний дараа цааш Зөвлөлтийн цэргийн ангиудыг үргэлжлүүлэн гаргажээ. Энэ тухай 1988 оны 10 дугаар сарын 26-ны БНМАУ Гадаад Явдлын Яамны Коллегийн хурлын протоколд холбогдох баримтад “... Монголд байгаа Зөвлөлтийн цэргийг цаашид үргэлжлүүлэн гаргахтай холбогдсон асуудлаар зохих байгууллагуудтай зөвлөлдөж манай талын баримтлах байр суурийн талаар санал боловсруулж 11 дүгээр сарын 5-ны наана удирдах байгууллагад оруулахыг нэгдүгээр орлогч сайдад даалгав.” гэжээ.

1989 оны 1 дүгээр сард Элчин сайд Ц.Гүрбадам ЗХУ-ын Гадаад Явдлын Яамны сайд Э.А.Шеварднзетэй уулзсан тухай тэмдэглэлд Оросын талаас “... Бид олон улсын хэлэлцээрээр хүлээсэн үүргээ биелүүлэхээр хичээж байна. 2 дугаар сарын 15 гэхэд Афганистанаас бүх цэргээ гаргах болно. Монголд байрлаж буй Зөвлөлтийн цэргийг 75 хувиар хорогдуулахтай холбогдсон асуудлууд байна. Цэргээ хорогдуулах асуудал амаргүй. Гэвч хорогдуулах нь цорын ганц зөв шийдвэр юм. Цэргээ гаргахдаа танай аюулгүй байдлыг хангах асуудлыг мөн бодолцох хэрэгтэй юм” гэжээ.

Улмаар Монголоос Зөвлөлтийн цэргийн анги нэгтгэлийг гаргах хоёр дахь шат нь 1989 оны 5 дугаар сард эхэлж, 1990 онд үргэлжилжээ. Энэ хугацаанд “Зөвлөлтийн цэргийн 75 хувийг гаргахаар төлөвлөсөн бөгөөд зарим мэдээгээр 80 орчим хувь гарсан бололтой. Энэ үед Зөвлөлтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл БНМАУ-аас танкийн дивиз 1, агаараас эсэргүүцэн хамгаалах бригад 3-ыг гаргасны дээр нисэх хүчний дивиз 1, нисэх хүчний хороо 1, нисдэг тэрэгний тусгай хороо 3-ыг тус тус гаргасан. БНМАУ-ын нутаг дэвсгэрт танк 404, их буу 307, нисэх онгоц 41, бие бүрэлдэхүүн 22900 хүн үлдсэн гэж мэдэгдэж байв.

Дараагийн шатанд тухайн үеийн олон улсын харилцаанд гарч байсан өөрчлөлт

шинэчлэлтэй холбогдож Монголоос Зөвлөлтийн цэргийн ангиудыг бүрэн гаргах асуудал үргэлжлэн яригджээ. ЗСБНХУ-аас Монголын саналыг хүндэтгэн үзэхээ мэдэгдсэн байна. Энэ тухай 1989 оны 10 дугаар сард БНМАУ-аас ЗСБНХУ-д суугаа элчин сайдын яаманд ЗХУ-ын Гадаад Явдлын Яамны Азийн социалист орнуудын хэлстийн дарга Ю.Д.Фадеевтай уулзсанд холбогдох баримтад Оросын талаас “...Монголоос Зөвлөлтийн цэргийг бүрэн гаргах тухай асуудлаар танай байр суурийг мэдмээр байна. Манай тал танай байр суурийг хүндэтгэнэ. Цэргийг Монголоос бүрэн гаргах нь улс төрийн асуудал юм. Хэрэв хоёр тал Зөвлөлтийн цэргийг бүрэн гаргахаар тохирвол цэргийн талын асуудлыг бид өөрсдөө шийдвэрлэнэ. Монголоос гаргаж буй цэргийг шингээх асуудал бол манай өөрийн дотоодын асуудал юм.” гэжээ.

Үүний дараа хоёр тал цэргээ хэрхэн гаргах асуудлаар саналаа солилцжээ. Энэ тухай 1989 оны 11 дүгээр сард БНМАУ-ын ГЯЯ-ны сайд Ц.Гомбосүрэн ЗХУ-ын элчин сайд В.И.Ситниковыг хүлээн авч уулзаж “... Манай нутаг дэвсгэрт үлдэх Зөвлөлтийн цэргийн хэсгийн үлдэх асуудал бол цэргийн тал бус улс төрийн үр нөлөө чухал болж байна. Уг асуудлыг бүрэн шийдвэрлэх нь бүс нутгийн энх тайван, аюулгүй байдлыг бэхжүүлэхэд бидний оруулах хувь нэмэр болох ёстой.” гэж байр сууриа илэрхийлжээ.

Монголын нутаг дэвсгэрээс Зөвлөлтийн цэргийн анги нэгтгэлүүдийг бүгдийг гаргах асуудлыг 1989 оны 12 дугаар сарын 21-нд БНМАУ-ын ГЯЯ-ны сайд Ц.Гомбосүрэн, ЗСБНХУ-ын ГЯЯ-ны сайд Э.А.Шевардназе нарын хийсэн хэлэлцээрээр эцэслэн тохирчээ. Энэ тухай баримтад Оросын талаас “... Монгол, Зөвлөлтийн нийгмийн өмнө өөрчлөн байгуулалтын том зорилт тавигдаж байна. Миний нэг ярих асуудал бол цэргийн тухай юм гэхэд Монголын тал... цэргийг анх оруулсан учир шалтгаан арилмагц тэднийг Монголын нутгаас бүрэн гаргана гэж бид нэг бус удаа мэдэгдэж байсан. Монгол-Хятад, ЗХУ-БНХАУ-ын харилцаа хэвийн болж байна. Цаашилбал дэлхий дахины байдал ерөнхийдөө сайжирч байгаад бид тус дөхөм үзүүлэх нь чухал учраас цэрэг гаргаж эхэлсэн. Энэ үйл явдлыг таслахгүйгээр үргэлжлүүлэх нь зохимжтой гэж үзнэ” гэжээ.

Ийнхүү Монголын талаас цэрэг гаргах асуудлыг 1991 оны эхний хагаст багтаан шийдэх хүсэлтэй байгаагаа илэрхийлж, уг асуудлыг шийдэх цагийг оновчтой олж, улс төрийн ач холбогдлыг бодолцох чухал хэрэгтэй байгааг тухайгаа ярилцаж, оновчтой цагийг өнгөрөөвөл уг асуудлын ач холбогдол эрс буурах аюултай болохыг сануулж, асуудлыг шуурхай шийдэх арга хэмжээ авахаар тохиролцсон байна.

Судлаачдын тэмдэглэж байгаагаар “Монголын нутаг дэвсгэрээс 1987-1992 онд 6 жилийн турш Оросын цэргийн томоохон бүлэглэл болох ерөнхий цэргийн 39 дүгээр арми, түүнд үл хамаарах цэргийн нэгтгэл ангиудыг гаргасан байна. “Засгийн газрын мэдээ” сонины 1995 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн №111-112-т мэдээлсэнээр “ Монголын нутгаас Оросын 82000 мянган цэргийн албан хаагч (Гэр бүлийн хамт 100 мянга илүү), 1866 танк, 2531 байлдааны хуягт машин, 315 нисэх онгоц, нисдэг тэрэг, 1416 их буу, миномет гаргав.” гэжээ.

Хоёр талын Гадаад явдлын яамны сайд нарын тохиролцсоны дараа өдөр 1989 оны 12 дугаар сарын 22-нд ЗСБНХУ-ын Коммунист Намын Төв Хорооны шийдвэр гарчээ. Энэ тухай ЗХУ-ын Засгийн газрын урилгаар ажлын айлчлал хийсэн БНМАУ-ын ГЯЯ-ны сайд Ц.Гомбосүрэнтэй ЗСБНХУ-ын ГЯЯ-ны сайд Э.А.Шеварднзетай ирж уулзсан баримтад Оросын талаас "... танайд байрлаж байгаа цэргийн ангиудыг бүрэн гаргах асуудлаар өчигдөр шийдвэр гарлаа. Хугацааны тухайд танай талын хэлсэн хугацаанд багтааж шийдвэрлэнэ" гэдгээ мэдэгджээ.

Ийнхүү айлчлал амжилттай болж, Зөвлөлтийн цэргийн ангиудыг бүрэн гаргах улс төрийн шийдвэр гарсан бөгөөд 1991 оны эхний хагаст багтаан бүрэн гаргах эцсийн тохироог хийсэн байна. Монголд байрлаж байсан Зөвлөлтийн цэргийн ангиудыг гаргах улс төрийн шийдвэр гарсны дараа уг үйл явцын гурав дахь шат буюу сүүлийн хэсгийг гаргах асуудлыг хоёр талын харилцан тохиролцсоноор 1991 онд байлдааны ангиудыг, 1992 онд ар тал, аж ахуй, барилга, төмөр замын цэргийг гаргажээ. Ийнхүү Оросын цэрэг Монгол Улсаас 1992 оны 12 дугаар сарын 30-нд гарч дууссаныг дэлхий нийтэд зарласан байна.

Эцэст нь дүгнэхэд ХХ зуунд Зөвлөлтийн арми нь Монгол Улсад хэд хэдэн удаа байрлаж, улс төрийн олон асуудлыг шийдэхэд тэр дундаа тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг сахин хамгаалахад чухал хувь нэмэр, нөлөө үзүүлсэн. Зөвлөлтийн цэрэг байрлаж байсан, тухайн үед байрлуулах болон гаргах болсон шалтгаан, олон улсын нөхцөл байдал нь цэрэг стратегийн зорилттой, олон хүчин зүйлтэй холбоотой боловч эцсийн дүндээ байрлаж байсан үүрэг зорилгоо бүрэн биелүүлж, манай улсад зохих хэмжээнд нааштай үр нөлөө үзүүлж чадсаныг тэмдэглэх хэрэгтэй юм.

### Ашигласан материал

1. ГХТА.Ф2.Д3.ХН486
2. ГХТА.Ф2.Д3.ХН529
3. ГХТА.Ф2.Д3.ХН535
4. ГХТА.Ф2.Д3.ХН541
5. ГХТА.Ф2.Д3.ХН542
6. Улаан Од сонин. 1978.04.15.№31
7. Улаан Од сонин. 1984.03.17.№19
8. Правда сонин. 29 июля 1986.№210
9. Улаан Од сонин. 1987.01.17.№6.
10. Засгийн газрын мэдээ сонин. 1995.08.31.№111-112
11. Д.Гомбосүрэн. Монгол дахь Зөвлөлтийн цэрэг. Батлан хамгаалах судлал сэтгүүл.2004. №2 (12)